



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 3 дугаар сарын 27 өдөр Дугаар 22

Хэрлэн сум

ХХII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын хурал Онцгой комиссын ажиллах журмын 1.8-д заасны дагуу цомхотгосон хэлбэрээр 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 100 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

- 1.Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг хүүхэд залуус, иргэд, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад эрчимжүүлж ажиллах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай: Эрүүл мэндийн газрын дарга Ч.Оюунаа,
2. Ариутгал, халдваргүйтгэлийн болон хог цэвэрлэгээний ажлын явц байдал: Мэргэжлийн хяналтын газар, Хэрлэн сум, Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын дарга нар,
3. Согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд тавих хяналтын тухай: Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
4. Улсын Онцгой комиссын дарга, гишүүд Дорнод аймагт ирж ажиллах тухай: Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа,
5. Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн зарцуулалтын талаар санал: Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газрын дарга нар,
6. Жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд тулгамдаж буй асуудлын талаар: Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Алимаа,
7. Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх эрчимжүүлсэн сургалтын явц байдал: Боловсрол, соёл урлагийн газрын дарга А.Нансалмаа,
8. Цаг агаарын төлөв байдал, хуурайшилтын зэрэг, цаашид сэрэмжлүүлэх зүйлийн талаар: Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга М.Алтаннавч,

9. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын явц байдал, тус ажлыг эрчимжүүлэх, энэ сард гарсан түймрийн шалтгаан нөхцөл, байгаль орчинд болон эд хөрөнгөд учирсан хохирол, унтраахад гарсан зардлын талаар: Бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах,

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Ч.Оюунаад:

1.1.Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах тухай мэдээ, мэдээллийг нийт иргэдэд хүргэх ажлыг Өрхийн эрүүл мэндийн төв, сумын Эрүүл мэндийн төвүүдэд үүрэг чиглэл өгч сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэхийг,

Хоёр. Мэргэжлийн хяналтын газар, Хэрлэн сумын Засаг дарга,

“Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ-ын дарга нарт

2.1.Аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн “Цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн ажил зохион байгуулах тухай” А/180 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж энэ ажилд оролцох, хүн хүч, техник хэрэгслийн тооцоог гаргаж танилцуулахыг,

Гурав. Гаалийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Гадаадын иргэн, харьяатын газрын Зүүн бүс дэх газар, Хилийн 0275 дугаар ангийн дарга, захирагч нарт:

3.1. Хилийн Ульхан боомтод үүрэг гүйцэтгэхдээ Мартын 8-ны баярыг тэмдэглэж Улсын Онцгой комиссын 2020 оны 03 дугаар тогтоолын 4 дэх заалтыг зөрчсөн алба хаагч нарт хариуцлага тооцож аймгийн Онцгой комисст мэдэгдэхийг,

Дөрөв.Бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандахад:

4.1.Цагдаагийн газарт иргэн Г.Бат-Оршихоос 500,000 төгрөгийн тусламжийг өгснийг “Хүмүүнлэгийн тусламж зохицуулах журам”-ын дагуу аймгийн Онцгой комисст хүлээлгэн өгсөн. Цагдаагийн газрын алба хаагч нарын хамгаалах хувцас, хэрэглэлээр хангах зорилгоор “Төгсфармакон” ХХК-тэй гэрээ байгуулсаны дагуу Дотоодын хандив тусламжийн сангаас 500,000 төгрөгийг олгохыг,

4.2.Цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай 9,520,000 төгрөгийн зардлыг Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн сангаас олгохыг,

4.3.Сум, байгууллагын ой, хээрийн түймэр унтраахад гарсан зардлыг тухайн сардаа багтаан шийдвэрлүүлж байхыг,

Тав.Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын

гишүүн А.Нансалмаад:

5.1.Дорнод аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөж буй 775 сурагчдад интернет ашиглаж онлайн орчноор суралцах

боломжийг бүрдүүлэхэд шаардлагатай 4,262,500 төгрөгийг ерөнхий боловсролын сургуулиудын ус, халаалт, цахилгааны хэмнэгдсэн зардлаас шийдвэрлэхийг,

Зургаа.Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, Онцгой

комиссын гишүүн Б.Эрдэнэбаярт,

6.1.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн төвөөс гарах, орох улсын болон орон нутгийн чанартай 5 автозамд хяналт, шалгалтын цэг гаргахыг,

6.2.Хил хамгаалах байгууллагатай хамтран хилийн болон ой, хээрийн түймрээс хамгаалах зурвасыг нөхөн сэргээх ажлыг чанартай зохион байгуулах, холбогдох зардлыг тухайн жилийн аймгийн төсөвт тусгуулан ажиллахыг,

Долоо."Чойбалсан хөгжил" орон нутгийн өмчит аж ахуйн

тооцоот үйлдвэрийн газрын дарга Б.Тэгшжаргалд:

7.1.Суурин газарт цэвэрлэсэн өвс шатааснаас ахуйн гал түймэр гарах тохиолдол гарч болзошгүй тул хазаар өвсийг цэвэрлэх багаж хэрэгслийг зохион бүтээх шинэлэг санал санаачлагыг гаргаж Бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газарт танилцуулахыг,

Найм. Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн

хурандаа Т.Ганзориг, Гадаадын иргэн, харьяатын газрын

Зүүн бүс дэх газрын дарга Б.Тамир нарт

8.1.Баянтүмэнгийн гүүрийн постод тус бүр нэг алба хаагчийг томилон ажиллуулж, тээврийн хэрэгслээр зорчиж буй гадаад улсын иргэдийн ажлын зорилго, байрлах хаягыг бүртгэх, бусад иргэдэд ой, хээрийн түймрээс урьдчилан заавар, зөвлөмж өгч ажиллах,

Ёс. Аймгийн Онцгой комиссын нийт гишүүдэд:

9.1.Мэргэжлийн байгууллагууд ой, хээрийн түймрийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэлтэй, нэгдсэн ойлголттой байх,

9.2.Хөдөө орон нутагт томилолтоор ажиллахдаа малчид, иргэдэд уулзаж ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр заавар зөвлөмж өгч тэмдэглэл хөтлөн аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад танилцуулж байхыг тус тус үүрэг болголоо.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГА

М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА, ДЭД ХУРАНДАА

Д.БАТТУЛГА